

Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, хөгжлийн дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд комиссын үүрэг оролцоо

Г.Соёлгэрэл Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог
хангах, үйлчилгээг сайжруулах төслийн зөвлөх

Удиртгал

- Сүүлийн 15 жилд дэлхий нийтээр болон монгол улсад хүүхдийн эрүүл мэнд сайжирч, эндэгдэл тууштай буурсан.
- Нас баралтыг бууруулахын зэрэгцээ хүүхдийн эрүүл мэнд, хөгжилд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлүүдийг багасгах, хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжсэнээр хүний амьдралын чанар сайжирна. Хөгжингүй орнуудад энэхүү амьдралын чанарыг сайжруулахад чиглсэн арга хэмжээ нь хэдийнээ хэвшсэн байна.

Дэлхий дахины чиг хандлага

- Аливаа эмгэгийг бага насанд нь олж илрүүлэн, даруй оношилж, даамжраагүй байхад нь холбогдох үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авснаар хүүхдийн хөгжлийг цогцоор нь дэмжиж, хамгаална.
- Цогцоор: бие махбод, оюун ухаан, хөдөлгөөн, танин мэдэхүй, нийгэмших гм


Эрт илрүүлэг чухал болох нь

UNCRPD Article 26 (a).


Хүүхдийн хөгжлийн хоцрогдол бэрхшээлийг эрт илрүүлэхийн чухлыг олон улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцид *...”тухайн хүний хэрэгцээ боломжид нийцсэн олон мэргэжилтнүүдийн үнэлгээг үндэслэн хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээг аль болох эрт эхлэх”* хэрэгтэй хэмээн тэмдэглэсэн байдаг.

Хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийг бага балчир насанд нь илрүүлэн даруй хөгжлийн дэмжлэгт хамруулах талаар олон улсын чиг хандлага, Монгол улсад нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг төр засгаас дэмжиж “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол нийгмийн хамгааллын комисс”-ыг байгуулсан.

- Тус комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүлд тогтвортой дэмжлэг, үйлчилгээг баталгаатай хангахад чиглэсэн **эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгаалал, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих болон нийгмийн бусад үйлчилгээнүүдийн уялдааг хангасан** салбар дундын зохицуулалтыг цаг алдалгүй, тасралтгүй хийхэд чухал үүрэгтэй байх болно.



Эрт илрүүлэлт, эрт үеийн хөгжлийн дэмжлэгийн тогтолцооны загвар



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГИЙН ТОГТОЛЦОО

- Хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэг -скрининг
- Оношилгоо / Үнэлгээ
- Хөгжлийн дэмжлэгийн төлөвлөгөө
- Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ
- Боловсролын үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх

18 сартай хүүхэд

- Харилцааны болон хэл ярианы хоцрогдол нь 18 сартайд мэдэгддэг. Хөнгөн хэлбэрийн хөдөлгөөний хоцрогдол мэдэгдэхгүй байсаар 18 сартайд тодорхой илэрдэг. Хүүхдийг 18 сартайгаас хөдөлгөөний хоцрогдлыг сэргээн засах, хэл ярианы хөгжлийг дэмжихэд үр дүнтэй. Мөн энэ үед хөгжлийг үнэлэх ерөнхий асуумж болон аутизмын өвөрмөц асуумжийг ашиглах боломжтой. 18 сартайд аутизмын шинж илэрдэг бөгөөд хөгжлийн дэмжлэг үзүүлэх боломжтой.

30-36 сартай хүүхэд

- Энэ насанд хүүхдийн хөдөлгөөн, хэл яриа, танин мэдэхүйн хөгжлийн үзүүлэлтүүдийг хэмжих тодорхой иж бүрэн үзлэгээр аливаа хоцрогдлыг илрүүлж, цаашид үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд илгээх боломжтой. Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр дэх тухайн насны асуумжийг эх эцэг хариулж бичих нь төдийлөн төвөгтэй биш. Хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байгаа бол багш нь үе тэнгийнхэнтэй нь жишиж хөгжлийн хоцрогдол, өөрчлөлтийг илрүүлэх ч тохиолдол гардаг.

Эрт илрүүлэг буюу Урьдчилан сэргийлэх үзлэг (скрининг)


Эрт илрүүлэг буюу урьдчилан сэргийлэх үзлэг гэдэг нь **зорилтот бүлгийн эрүүл хүн амыг** нэгдсэн үзлэг эсвэл шинжилгээнд хамруулж тэднээс тодорхой өвчин эмгэгийн эрсдэлтэй хүнийг олж, илрүүлэн цаашид нарийвчилсан оношилгоо, үнэлгээ, шинжилгээ хийж баталгаажуулахад чиглэсэн арга юм.

- Хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх үзлэгийг өрх, сумын эрүүл мэндийн төв, цэцэрлэг, сувилал гэх мэт бага насны хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд дээр сонсгол, харааны үзлэг хийх болон дархлаажуулалтын аян зэргийг ашиглан зохион байгуулж болно.

Дараах шатны үйлчилгээнд илгээх

- Эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгээр эрүүл мэндийн болон хөгжлийн үзүүлэлт нь асуудалтай байвал цаашид мэргэжлийн эмчид илгээх, хөгжлийн үнэлгээ, шинжилгээ болон оношилгоо хийлгэх шаардлагатай. Энэхүү нарийвчилсан үнэлгээгээр тухайн хүүхдэд ямар нэг эмгэг, хөгжлийн хоцрогдол байгааг тогтоон, эмчилгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх ямар үйлчилгээ шаардлагатайг тогтооно.

Эрт үеийн хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах үйл явц



Эрт илрүүлэлт



- Хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрсдэлтэй хүүхдийг анхан шатны эрүүл мэндийн үйлчилгээ, (эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, эсвэл эрүүл мэнд, хөгжлийн иж бүрэн үзлэг), цэцэрлэг, сургуулиар олж илрүүлэн, хоёр, гурав дахь шатлалын мэргэжлийн тусламж үйлчилгээнд илгээнэ.

Хүүхдэд тусламж үзүүлдэг нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд нь хүүхдэд иж бүрэн үзлэг шинжилгээ хийх зорилгоор хүүхэд, мэдрэл, сэтгэц, чих хамар хоолой, нүд г.м мэрэгжлийн эмч нар, сэтгэл зүйч, хөдөлгөөн засалч (PT), ахуй засалч (OT), хэл засалч (ST) нийгмийн ажилтан зэрэг холбогдох мэргэжилтнүүдээс бүрдсэн Төрөлжсөн мэргэжлийн багийг байгуулна.

Оношилгоо/
Үнэлгээ



- Хоёр, гуравдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагад төрөлжсөн мэргэжлийн баг оношилгоо дүгнэлт, гаргаж орон нутгийн ХБХЭМБНХ-ын комисс руу илгээнэ.

Салбар комисс нь:

1. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахад хөгжлийн бэрхшээлтэйг тогтоох;
2. Хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах заавар өгч шийдвэр гаргах;
3. Хөгжлийн дэмжлэг үзүүлэх талаар холбогдох байгууллагуудтай холбон зуучлах үүрэгтэй.

Хөгжлийн
дэмжлэгт
хамруулах
шийдвэр



- Орон нутгийн ХБХЭМБНХ-ын комисс нь хөгжлийн бэрхшээлийг тогтоож, 1-халамжийн тэтгэмж олгох, 2 –хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргана. Үүнд: сэргээн засах, боловсролын үйлчилгээнд хамрагдах г.м.

Хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах

Хөгжлийн
дэмжлэг/
оролцооны
үйлчилгээ



- Төлөвлөгөөнд тулгуурлан хөгжлийн дэмжлэг, оролцооны үйлчилгээнд хамруулна.

Эрт илрүүлэг-Нотолгоонд суурилсан арга хэмжээ

Хүүхдийн өсөлт хөгжлийг тогтмол хянаж өсөлт хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийг мэдэж тогтоох нь өвчин эмгэг, хөгжлийн хоцрогдол бэрхшээл үүсэх эрсдэлээс сэргийлэх чухал ач холбогдолтой. Энэ нь үр дүнтэй хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээ үзүүлэх үндэслэл болдог

Баянгол дүүрэгт 2017 оны 5-р сард зохион байгуулсан үзлэгийн дүнгээс

Нийт үзлэгт хамрагдсан 377 хүүхдийн 2.9% нь ерөнхий, 2.9% нь нарийн хөдөлгөөний, 11.1% нь хэл ярианы, 13.7% нь танин мэдэхүйн, 0.5-4.5% нь нийгэмшихүйн хоцрогдолтой, 2.1% нь харааны, 0.3% нь сонсголын бэрхшээлтэй байж болзошгүй бөгөөд 29.4% нь 18 сартайдаа угжаар уусаар байгаа, 42.6% нь тогтмол цагаар хооллодоггүй болох нь илэрч байв.

